



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2020 оны 12 сарын 28 өдөр

Дугаар 713

Улаанбаатар хот

Шалгалтын мөрөөр авах арга хэмжээний тухай

Улсын хоёрдугаар төв эмнэлэгийн 2019 оны байдлаархи үндсэн хөрөнгийн хөдлөл, хөдөлгөөн, ашиглалт, хадгалалт, хамгаалалт, захиран зарцуулалт, эзэмшил газрын эрх зүйн үндэслэл, байр талбайн түрээсийн үйл ажиллагаанд хийсэн баримтын шалгалтын явцад элэгдлээрээ анхны үнээ нөхсөн, ашиглалтын шаардлага хангахгүй технологийн хоцрогдолд орсон зарим нэр төрлийн үндсэн хөрөнгийг он удаан хугацаанд хадгалж байгаа, гадаадын тусламжаар баригдсан хүүхдийн эмнэлгийн байрыг улсын комисс хүлээж аваагүй байхад ашиглалтад оруулсан зэрэг зөрчил, дутагдал илэрснийг тэмдэглээд Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 1, 2, 66 дугаар зүйлийн 3 дахь хэсгийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Улсын хоёрдугаар төв эмнэлэгийн 2019 оны үндсэн хөрөнгийн ашиглалт, хадгалалт, хамгаалалт, захиран зарцуулалтад хийсэн шалгалтын явцад илэрсэн зөрчил, дутагдлыг арилгах арга хэмжээний жагсаалтыг хавсралтаар баталсугай.

2. Улсын хоёрдугаар төв эмнэлэгийн ерөнхий захирал С.Энхболдод санхүүгийн сахилга батыг хэвшүүлэн, дотоод хяналтыг сайжруулж дараах арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг үүрэг болгосугай:

2.1. Шалгалтын тайланд дурдсан зөвлөмжийг хэрэгжүүлэх төлөвлөгөө боловсруулж ажиллах;

2.2. Үндсэн хөрөнгийн агуулахад байгаа ашиглалтын шаардлага хангахгүй 6 нэр төрлийн 27.4 сая төгрөгийн балансын үнэ бүхий үндсэн хөрөнгийг актлуулах асуудлыг холбогдох журмын дагуу Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт тавьж, шийдвэрлүүлэх;

2.3. БНХАУ-ын Энхтайван найрамдлын сангийн 1771.5 сая төгрөгийн өртөг бүхий /суурьлагдсан тоног төхөөрөмжийн хамт/ улсын хоёрдугаар төв эмнэлгийн харьяанд баригдсан “Хүүхдийн эмнэлэгийн барилга”-ыг улсын комисс хүлээн авч, эрх бүхий байгууллагаас гэрчилгээ олгоогүй байхад ашиглаж эхэлсэн байна. Энэ нь Монгол Улсын барилгын тухай хуулийн холбогдох заалтыг зөрчиж байгаа тул барилгыг улсын комиссын дүгнэлтийг үндэслэн, зохих данс бүртгэлд бүртгэх;

2.4. Байшин барилга, машин техникийн өнөөгийн үнэ цэнийг тодорхойлох сэргээн босголтын зардлыг тусгасан тухайн хөрөнгийн хувийн хэргийн баяжуулалтыг чанаржуулж, Барилга, хот байгуулалтын сайдын “Барилга байгууламжийн хувийн хэрэг хөтлөх журам батлах тухай” 2016 оны 180 дугаар тушаалыг хэрэгжүүлж ажиллах;

2.5. Шалгалтаар илэрсэн зөрчил дутагдлыг арилгах төлөвлөгөөний биелэлтийг 2021 оны 1 дүгээр улиралд багтаан Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлэх.

1320177

3. Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн Хяналт шалгалтын хэлтэс (Ц.Түвшинзаяа)-т даалгасугай.

ДАРГА


Б.ЦЭНГЭЛ

~~ТӨРИЙН ӨМЧИЙН ХЯНАЛТ
ШАЛГАЛТЫН ХЭЛТСИЙН
ДАРГА~~

Ц.ТҮВШИНЗАЯА



Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2020 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн 713 дугаар тогтоолын хавсралт



Шалгалтаар илэрсэн зөрчил, дутагдал, түүнийг арилгах арга хэмжээний жагсаалт

| № | Зөрчил, дутагдлын утга | Хариуцах эзэн | Дүн /мян.төгрөг/ | Зөрчил дутагдлыг арилгах талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээ |
|---|---|---|------------------|--|
| 1 | Ашиглалтын шаардлага хангахгүй 6 нэр төрлийн үндсэн хөрөнгийг удаан хугацаагаар хадгалсан | Захирал С.Энхболд Ерөнхий ня-бо А.Байгальсүрэн | 27,400.0 | Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам батлах тухай" эд хөрөнгийн хөдлөл хөдөлгөөнийг зохицуулсан 2019 оны 271 дүгээр тогтоолыг хэрэгжүүлж |
| | Дүн | | 27,400.0 | |
| 2 | Улсын хоёрдугаар төв эмнэлгийн харьяанд баригдсан "Хүүхдийн эмнэлэгийн барилга"-ыг улсын комисс хүлээн авч, эрх бүхий байгууллагаас гэрчилгээ олгоогүй байхад ашиглалтад оруулсан | Захирал С.Энхболд Ерөнхий ня-бо А.Байгальсүрэн | | Барилгын тухай хуулийг мөрдөн ажиллаж, улсын комист яаралтай хүлээлгэн өгөх, |